### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 184,897.8 мянган төгрөгөөр буюу 15,7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
<b>Мөнгөн хөрөнгө</b>	-	-	-
<b>Авлага</b>	2,300.0	7,293.7	4,993.7
<b>Урьдчилгаа</b>	-	-	-
<b>Бараа материал</b>	142,483.4	238,292.3	95,808.9
<b>Үндсэн хөрөнгө</b>	1,036,614.0	1,120,709.2	84,095.2
<b>Нийт хөрөнгө</b>	1,181,397.4	1,366,295.2	184,897.8
<b>Өр төлбөр</b>	400.0	400.0	-
<b>Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/</b>	1,180,997.4	1,365,895.2	184,897.8
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	1,181,397.4	1,366,295.2	184,897.8

Дээрх хүснэгтээс харахад: Бараа материал дансны хувьд бичиг хэргийн материал

36,621,000.0 мянган төгрөг, аж ахуйн материал 27,022,150.0 мянган төгрөг, түлш, шатах тослох материал 1,184,250.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Авлага дансны хувьд урд оны үлдэгдэл 1,700.0 мянган төгрөг барагдаагүй байна. Тайлант онд Орон нутгийн хөгжлийн сангийн малын тоо толгойн албан татварын мөнгөөр малчдын зөвлөгөөнд эмэгтэй малчдад 950,0 төгрөгийн сарнай, Засаг даргын нөөц хөрөнгөнөөс аймгийн аварга малчдыг 400,00 төгрөгөөр шагнаж төсвийг зориулалт бусаар зарцуулсан Баянжаргалан сумын Засаг даргад 1,350.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн бөгөөд Санхүү хяналт, дотоод аудитын албаны шалгалтаар 3,643.7 мянган төгрөгийн өвс тэжээлийн авлага үүсгэх зөвлөмж өгсний дагуу авлагын данс нэмэгдсэн байна.

Тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 12,224.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 6,853.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 3,000.0 мянган төгрөгийн программ хангамж худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 190,512.0 мянган төгрөгийн барилга байгууламж, орон сууц, 10,000.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 20,500.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 20,500.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө хүлээн авч, үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна. Мөн 94,859.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан байна. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,365,895.0 мянган төгрөг болж 184,898.0 төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 384,008.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 144,459.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 2023 оны урсгал зардлын төсвийг 528,467.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь 2023 онд алба хаагчдын цалин шат дараатайгаар нэмэгдсэнээс шалтгаалан орон нутгийн төсвийн санхүүжилтийн хэмжээ нэмэгдсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 528,917.5 мянган төгрөгөөс 1 удаа тодотгол хийж 528,467.4 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Урьд оны үлдэгдлээс санхүүжсэн дүн 3,950.1 мянган төгрөг, Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 532,417.5 мянган төгрөгийн санхүүжилтийг авч бүрэн зарцуулсан байна. Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 521,706.9 мянган төгрөг буюу 93,6 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106/80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	385,685.7	379,922.4	5,763.3	98.5%
2	70106/80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	51,881.4	51,135.5	745.9	98.6%
3	70106/80106 Баг, хорооны үйл ажиллагааны зардал	60,400.3	57,773.2	2,627.1	95.6%
4	70106/80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	2,000.0	2,000.0	0.0	100.0%
5	70106/80918 Бусад	18,950.1	18,900.2	49.9	99.7%

6	70106/81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	5,000.0	4,992.2	7.8	99.8%
7	71411/82801 Улсын их баяр наадам	5,000.0	5,000.0	0.0	100.0%
8	71411/82212 Хур хог хаягдал, орчны бохирдлыг	3,500.0	1,983.4	1,516.0	56.7%
	ДҮН	532,417.50	521,706.90		93.6%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны захирагчаас орон нутгийн нэмэгдэл цалинд олгох санхүүжилт 34,700.6 мянган төгрөг, өвс тэжээлийн орлого 18,205.7 мянган төгрөг, нийгмийн хариуцлагын гэрээ, хандиваар 7,500.0 мянган төгрөг, ус, картын орлого 11,500.0 мянган төгрөг, дээд газраас шилжиж орж ирсэн 8,230.9 мянган төгрөгийн орлого орсон байна. Үүнээс орон нутгийн нэмэгдэл цалинд 33,597.3 мянган төгрөг, шатахуунд 375.0 мянган төгрөг, бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 605.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 39,809.1 мянган төгрөг нийт 74,386.4 мянган төгрөгийг зарцуулж 5,750.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 2 хөтөлбөрийн 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	/мянган төгрөгөөр/	
					Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106/ орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01-2023.12.31	Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах	98.7%	523,917.50	514,723.50
2	71411/Хүрээлэн буй орчны бодлого удирдлага	2023.01.01-2023.12.31	хэвийн үйл ажиллагааг хангах	78.3%	8,500.00	6,983.40

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баянжаргалан сумын Засаг даргын Тамгын газар нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг гаргаж тушаалаар тусад нь баталгаажуулаагүй ба Баянжаргалан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/119 тоот захирамжаар баталсан байна.

Баянжаргалан сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд ТЕЗ-ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд багтсан 13,500.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, урсгал засварын материал, хог хаягдал зайлуулах, баяр наадмын зардлыг шууд худалдан авалт хийсэн. Шатахуун худалдан авах ажиллагааг тендер шалгаруулалтын онцгой журмаар зохион байгуулсан ба гүйцэтгэгчээр НИК ХК шалгарч гэрээ байгуулах эрх олгон барааг худалдан авч ажилласан.

Түлш халаалтыг Өв Баян Улаан ХХК, гэрэл цахилгааныг УБЦТС нийлүүлсэн байна.

Ай Ти Зон ХХК-аас ерөнхий гэрээгээр 5,840.0 мянган төгрөгийн зөөврийн компьютерыг тоног төхөөрөмж (222001) зардлаас худалдан авсан ба Өнө тэгш арвижих ХХК, Майтеч ХХК, Пүүл скель ХХК, Ухаалаг засаглал ХХК, Ай Ти Зон ХХК, Баясгалант төв ХХК-аас 10,620.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, программ, бараа материалыг тоног төхөөрөмж (222001), бусад хөрөнгө (223001) зардлуудаас тус тус шууд худалдан авалт хийсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Адъяасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06/07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны баталсан төсвийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газрын батлагдсан 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт орлого 744,756.3 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 11,171.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 8,378.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт мэдээлбэл зохих 165 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож, 162 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлсэн байна. Үүнд: цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 21 орлогын, 12 зарлагын мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 3 шийдвэрийг хуулийн хугацаанд байршуулж мэдээлсэн ба төсөв зарцуулах 11 шийдвэр, тендерт шалгарсан оролцогчийн талаарх товч мэдээлэл цэсэд 1 мэдээллийг мэдээлээгүй байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж, 3 албан шаардлага өгөгдсөнийг 100 хувь хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдөр 05/159 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	3	32.350.7	3	32.350.7	100%
Зөвлөмж	2	12,702.0	2	12,702.0	100%
Нийт дүн	5	45.052.7	5	45.052.7	100%

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газрын дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

### Залруулсан алдаа

Аудитаар нийт 130,168.1 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 130,168.1 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

1. Мөнгөн гүйлгээний журналаар нэг удаагийн тэтгэмж 1,000.0 мянган төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүйгээр зардлаар хаасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. ТӨАБЖСЗДТГ/202301002 дугаартай 362,427.0 мянган төгрөгийн тендер шалгаруулалтын үр дүнг болон цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 244,973.2 мянган төгрөгийн гүйлгээг шилэн дансны цахим системд мэдээлээгүй байна. Энэ шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3-д “Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6 дугаар зүйлийн 6.4.5-д “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заасныг тус тус зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

3. Үр дүнгийн тайланд орлого болон үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал, үндсэн хөрөнгийг Э-тайлантай зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

### 5.1 Төлбөрийн акт

1. Улс төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл цалин олгосон.

Илрүүлэлт: Төв аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн Б/02 тоот захирамж, Баянжаргалан сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/18 захирамжийг үндэслэн сумын Улс төрийн 5 албан хаагчид орон нутгийн нэмэгдэл 9,403.6 мянган төгрөг олгосон зөрчил илэрлээ. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.17-д “Захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгож болно”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”,

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 489 дүгээр “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоол, 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар “Журам батлах тухай” тогтоол болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

## **5.2 Албан шаардлага**

### **1. Хөрөнгийн тооллого хийгээгүй.**

Илрүүлэлт: Хөрөнгийн тооллого явуулах ажлын хэсэг томилсон тушаалыг А/06, А/09, А/17 дугаартай тус тус гарсан боловч тооллогын ажлын хэсэг (дарга) тооллогыг бүрэн хийж тооцоо бодоогүй тушаалаар ногдуулсан албан үүргээ хэрэгжүүлээгүй, хариуцлагагүй ажилласан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “Хариуцлагатай байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 “Төрийн өмчийн хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад хуульд заасан хугацаанд болон зайлшгүй шаардлагатай үед хийнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.6 “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалын 3.8 “Эд хөрөнгийн тооллогын бүртгэл”-д заасныг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх” “оршин байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтын дагуу хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

## **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1. Арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Баянжаргалан сумын ЗДТГ-ын 2022 оны авлагын үлдэгдэл 2,300.0 мянган төгрөг барагдаагүй байна. Мөн тайлант онд нэмж 4,993.7 мянган төгрөгийн авлага үүссэн ба авлагын үлдэгдэл нийт 7,293.7 мянган төгрөг байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “Хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлагыг барагдуулах зөвлөмж өгөв.

## 2. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Баянжаргалан сумын ЗДТГ-ын биет бус хөрөнгийн бүртгэлд 3 газар, Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн газрын бүртгэлд 21 газар бүртгэлтэй байгаа бөгөөд бүртгэгдсэн газрын тоо болон үнэлгээний дүн тус тус зөрүүтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, Газрын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Газрыг Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэн /цаашид "иргэн" гэх/, аж ахуйн нэгж, байгууллага энэ хуульд заасны дагуу эзэмшиж ашиглана”, 23 дугаар зүйлийн 23.3.9 “Аймаг нийслэлийн газрын алба нь газар эзэмших, ашиглах эрхийг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28.1-д заасан журмын дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх эрхтэй”, 23 дугаар зүйлийн 23.4.3 “Сумын газрын даамал, дүүргийн газрын алба нь эзэмшил, ашиглалтад олгогдсон газрын хэмжээ заагийг газар дээр нь тэмдэгжүүлж, координатжуулах, тэдгээрийн кадастрын зургийг үйлдэж, газрын улсын бүртгэлд бүртгэх эрхтэй”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх зарчим” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газрын харилцаа барилга хот байгуулалтын газартай тооцоо нийлэх, зөрчлийг арилгах зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлагналтай холбоотой алдаа	3	130,168.10			3	130,168.10	3	130,168.10				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>130,168.10</b>			<b>3</b>	<b>130,168.10</b>	<b>3</b>	<b>130,168.10</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Үүнээс		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Улс төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл цалин олгосон.	1	9,403.6	1	9,403.6	-	-	-	-	-	-	-	-
Хөрөнгийн тооллого хийх албан үүргээ	1	1,756,501.9	-	-	1	1,756,501.9	-	-	-	-	-	-

хэрэгжүүлээгүй хариуцлагагүй ажилласан ажилтнуудад хариуцлага тооцуулах.												
Авлага өссөн.	1	7,293.7	-	-	-	-	1	7,293.7	-	-	-	-
Дүн	3	1,773,199.1	1	9,403.6	1	1,756,501.9	1	7,293.7	-	-	-	-

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Газрын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Баянжаргалан сумын ЗДТГ-ын биет бус хөрөнгийн бүртгэлд 3 газар, ГХБХБГ-аас ирүүлсэн газрын бүртгэлд 21 газар бүртгэлтэй байгаа бөгөөд бүртгэгдсэн газрын тоо болон үнэлгээний дүн тус тус зөрүүтэй байна.	1	-					1	-
Дүн	1	-					1	-

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)